



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2015 оны 6 сарын 17 өдөр

Дугаар А/333

Улаанбаатар хот

Салбар комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, "Архивын тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.1 дахь заалт, Ерөнхий сайдын 2015 оны 124 дүгээр захирамж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 44 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн хэмжээнд "Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг"-ийг зохион байгуулах дүүргийн салбар комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсгийг байгууллага бүр дотооддоо байгуулж, үзлэгийн бэлтгэл зохион байгуулалтыг сайтар хангаж, амжилттай дүгнүүлэх, салбар комиссоос үзлэг явуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг үзлэгт хамрагдах нийт байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Батлагдсан төлөвлөгөөний дагуу үзлэгт хамрагдах байгууллагын жагсаалт, хуваарийг гарган батлуулж, үзлэгийн бэлтгэлийг хангах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, үзлэгийн нэгдсэн дүн мэдээ болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, хангалттай дүгнэгдсэн байгууллагын удирдлага, ажилтнуудыг шагнаж урамшуулах, хангалтгүй дүгнэгдсэн байгууллагын удирдлагуудад зохих арга хэмжээг төлөвлөж, дүүргийн Удирдах зөвлөлийн хуралд танилцуулан ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтийг хянаж ажиллахыг Засаг даргын Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан Орлогч /Б.Мөнхбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ГАНБОЛД

1150200994

Дүүргийн Засаг даргын 2015
оны .6... сарын /7-ны өдрийн
А/..... дугаар захирамжийн 1 дүгээр
333 хавсралт

“АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН УЛСЫН ҮЗЛЭГ”-ИЙГ УДИРДАН
ЗОХИОН БАЙГУУЛАХ ДҮҮРГИЙН САЛБАР КОМИССЫН
БҮРЭЛДЭХҮҮН

| | | |
|-----------------|----------------|--|
| Комиссын дарга: | Ж.Эрдэнэбат | Засаг даргын Тамгын газрын дарга |
| Гишүүд: | А.Дамцагдорж | Захиргаа, хуулийн хэлтсийн дарга |
| | Ж.Орхонбаяр | Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| | Д.Булган | Худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга |
| | Я.Орломсүрэн | Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга |
| | С.Янжинхорлоо | Эдийн засаг төлөвлөлтийн хэлтсийн дарга |
| | А.Гэрэлт-од | Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн дарга |
| | Ж.Даваарагчаа | Цэргийн штабын дарга |
| | Ц.Жаргалтай | Дотоод аудит |
| | П.Амартүвшин | Хороо хариуцсан мэргэжилтэн |
| | Э.Онон | Эрх зүй хуулийн мэргэжилтэн |
| | О.Нямбат | Хүний нөөц, шагнал урамшуулал хариуцсан мэргэжилтэн |
| | Б.Лхагваням | Дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн |
| | С.Энхцацрал | Архивын эрхлэгч |
| | Г.Ганцэцэг | Бичиг хэргийн эрхлэгч |
| | Я.Жаргалсайхан | Онцгой байдлын хэлтсийн дарга |
| | Д.Баянмөнх | Бүртгэлийн хэлтсийн дарга |
| | М. Алтансүх | Өмч, газрын харилцааны албаны дарга |
| | О.Болд | Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга |
| | Н.Ариунаа | Нийгмийн даатгалын хэлтсийн дарга |
| | Ж.Эрдэнэбилэг | Татварын хэлтсийн дарга |
| | Д.Мөнхзул | Статистикийн хэлтсийн дарга |

| | |
|--------------|---|
| Т.Ням-очир | Боловсролын хэлтсийн дарга |
| А.Сэрээтэр | Хөдөлмөрийн хэлтсийн дарга |
| Ц.Энхболд | Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга |
| Ц. Лхагва | Эрүүл мэндийн төвийн дарга |
| Р. Очирпүрэв | Биеийн тамир спортын хорооны дарга |
| П. Батбаатар | Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн дарга |
| О.Амарсанаа | Цагдаагийн 2 дугаар хэлтсийн дарга |
| Б.Сүхбат | Замын цагдаагийн тасгийн дарга |
| А.Зул | Ахмадын хорооны дарга |
| С.Жамьяндорж | Худалдан авах ажиллагааны албаны дарга |

Комиссын

нарийн бичгийн

дарга:

Ш.Цэцэгмаа

Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн